



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 178

Мандагловь

Мал амьтны сэг зэмийг цуглуулж
устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын албан даалгавар, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/84 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уст цэг, үерийн жалга, усны эх булаг, орон нутгийн төв замын дагуух үхсэн мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Е.Отгонцэцэг (Мал эмнэлгийн тасгийн дарга,
улсын байцаагч)

Гишүүд: Д.Миеэсүрэн (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Т.Батсайхан (ХАА тасгийн дарга)

Наран багт: Н.Баярсайхан (Багийн засаг дарга)

Тэвш багт: Ш.Батбаатар (Багийн засаг дарга)

Далай багт: Ж.Зоригтбаатар (Багийн засаг дарга)


Үйзэн багт: Т.Батжаргал (Багийн засаг дарга)

2. Мал, амьтны сэг зэм цуглуулж, устган, цэвэрлэх ажлын дөрвөн хэсэг гарган 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 11-ны өдрийг хүртэлх хугацаанд, чанартай зохион байгуулж дуусгахыг холбогдох багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, аюулгүй ажиллагаа, арга зүйн зааварчилгаа өгөн, тайлан мэдээг хугацаанд нь гарган өгөхийг Мал эмнэлгийн

тасгийн дарга, Улсын байцаагч (Е.Отгонцэцэг), Байгаль орчны хяналтын улсын
байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ